



БАЯНХОНГОР АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/03

Эмээлтолгой

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", 29.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 6.6, 16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйлийн 17.2.1, 19 дүгээр зүйлийн 19.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17, 4.1.22, 32 дугаар зүйлийн 32.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Нам толгой 1 дүгээр багийн нутаг Ар хаг, Хөндлөн хар, Улаан хуруунд мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин батлагдсан тул тус нутагуудын ойролцоох газрууд болох Хөндлөн арын сонгинот, Булган энгэр, Чихэн чулуу, Цагаан хороот, Шанд Гавхайстай, Мануухайт, Улаан хуруунаас, Ангархай ам хүртэлх бүс нутагтуудад 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 2022 оны 02 дугаар сарын 06-ны өдрийг хүртэлх 28 хоногийн хугацаанд хүн, мал, амьтны хөдөлгөөнд хатуу хөл хорионы дэглэм тогтоосугай.

2.Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээг оновчтой төлөвлөж шуурхай арга хэмжээ авч ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (С.Жаргалсайхан), Голомтын бүсийн мал сүрэгт үзлэг хийж, дархлаажуулах, ариутгал, халдваргүйтгэл хийх ажлыг "Ар хаг" Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын их эмч (С.Нанжид), "Давхарын нуруу" Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын их эмч (Б.Болормаа), Малчид, мал бүхий иргэдийг тус өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр хангаж, зөвлөн туслахыг багийн Засаг дарга (Ч.Цэдэвсүрэн)-д тус тус даалгасугай.

3.Хорио цээрийн дэглэм тогтоосон бүсээр дамжин өнгөрөх авто тээврийн хэрэгсэл, хэв журам сахиулж ажиллахыг хэсгийн төлөөлөгч (Б.Амарзаяа), Эрэн хайх аврах салбарын дарга (Д.Даваасүрэн), Хариуцлагатай жижүүр томилж цаг үеийн мэдээ мэдээллийг холбогдох газруудад түргэн шуурхай мэдээлж ажиллахыг Засаг

даргын орлогч (Д.Ганзориг), Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Лхам-Осор) нарт тус тус даалгасугай.

4.Сумын хэмжээнд амьд мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хориглож, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг 2, 3, 4 дүгээр багаас мал эмнэлгийн гэрчилгээг үндэслэн нийтийн хэрэгцээнд нийлүүлэх ажилд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (С.Жаргалсайхан), хэсгийн төлөөлөгч (дэслэгч Б.Амарзаяа, Эрэн хайх салбарын дарга (Д.Даваасүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

5.Хорио цээрийн дэглэм тогтоосон хугацаанд шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгө, Гамшгаас хамгаалах зардлаас гаргахыг Санхүүгийн албаны дарга (Д.Азжаргал)-д зөвшөөрсүгэй.

6.Хорио цээрийн дэглэм тогтоосон Өлийн дөрөлж, Ар хаг, Улаан хуруу, Ангархайн ам зэрэг газруудад хяналтын постод гарах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Ганзориг)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХЖАРГАЛ

